



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 306

Улаанбаатар хот

“Практикал даатгал” ХХК-ийн дүрмийн санг
нэмэгдүүлэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Практикал даатгал” ХХК-ийн дүрмийн санг тус компанийн 2013 оны хуримтлагдсан ашгаас хувьцаа эзэмшигчид хуваарилсан ногдол ашгийн мөнгөн хөрөнгө болох 750,000,000.00 /долоон зуун тавин сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	Гардайн Гантөмөр	2,750,000,000.00	750,000,000.00	3,500,000,000.00	100.0%
	Нийт	2,750,000,000.00	750,000,000.00	3,500,000,000.00	100.0%

2. Дүрмийн сангийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2015 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Практикал даатгал” ХХК /Ч.Даваажав/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000903